



## НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 05 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

### “Дөрвөн хайрхан”-ы нэрэмжит бүх нийтийн явган аялалыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/179, А/923 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Дөрвөн хайрхан”-ы нэрэмжит бүх нийтийн явган аялалыг 2018 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Д.Сүхбаатарын талбайгаас Дөрвөн хайрханы чиглэлд зохион байгуулсугай.

2. “Дөрвөн хайрхан”-ы нэрэмжит бүх нийтийн явган аялалыг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

3. Явган аялалыг зохион байгуулахад шаардагдах 10.870.000 /Арван сая найман зуун далан мянган/ төгрөгийг Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/923 дугаар захирамжаар батлагдсан төсвийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Л.Төгөлдөр/-д зөвшөөрсүгэй.

4. “Дөрвөн хайрхан”-ы нэрэмжит бүх нийтийн явган аялалын урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж хөтөлбөрийн дагуу зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтэс /А.Болдмаа/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

